

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	3
2.1.	Оршил .....	3
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	3
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	3
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	6
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан .....	12
4.2	Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4	Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.5	Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	19

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ХУДАЛДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИХ  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ М.ДОЛЖИН  
ТАНАА

2019.03.20 № 06/528  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага


Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*Ц. Наранчимэг*

Ц.НАРАНЧИМЭГ



## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг тус сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч М.Должин Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн албан томилолт, үндсэн хөрөнгө, шилэн данстай холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 10-наас 2019 оны 03 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК-ийн захирал Ч.Мөнхтуяа, чанарын хяналтын менежер А.Оюун, аудитор Э.Цэвээнсүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль нь “Инноваци, энтрепренершип, тогтвортой, ногоон хөгжлийн концепцид суурилсан сургалт, эрдэм шинжилгээг хослуулж хөдөлмөрийн зах зээлд тэргүүлэгч мэргэжилтэн бэлтгэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажилласан байна.

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль нь Засгийн газрын 2010 оны 15 дугаар тогтоолоор Монгол Улын Их Сургуультай нэгдэж Засгийн газрын 2017 оны 131 дүгээр тогтоолоор тусгаарлаж нэг салбар сургуультай бие даасан их сургууль болж үйл ажиллагааг нь дараахь чиглэлээр тодорхойлжээ. Үүнд:

- “Судалгаанд суурилсан их сургууль” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Олон Улсын болон Үндэсний хэмжээний судалгааны грант бүхий төсөл удирддаг, оролцдог байх;
- Реер review хийгддэг олон улсын сэтгүүлд хэвлүүлдэг бүтээлийн тоог нэмэгдүүлэх.
- Олон Улсын жишигт нийцүүлэн сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг өөрчилж, сайжруулах;
- Даян дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Боловсролын талаар төрөөс бармтлах бодлого, сургуулийн алсын хараа эрхэм зорилготой уялдуулан сургалтын үйл ажиллагааг явуулах;
- Сургалт судалгаа, үйлдвэрлэлийн түншлэлд түшиглэсэн Олон Улсын Стандартад нийцсэн тэгш хүртээмжтэй чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх;
- “Орлоготой оюутан” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;

- Амьдралын зөв дадал хэвшилтэй эерэг хандлагатай идэвхи санаачлагатай байгаль орчинд ээлтэй оюутныг төлөвшүүлэх;

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Дээд Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн мөрдөж байгаа Монгол улсын их сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Повер софт” програм хангамж ашигладаг байна.

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж,

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан 9 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь байгууллагын зардлын дансдад алдаа гарсантай холбоотой юм.

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,635.3 сая төгрөгийн 1 хувь буюу 16.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшинг дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 14 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж үнэлсэн, 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцноос 2 асуудлыг аудитын явцад залруулга хийлгэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

### **2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Худалдаа Үйлвэрлэлийн Их Сургуулийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

#### **2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал**



ХҮИС-ийн төв сургуулийн тайлан, Баянхонгор аймаг дахь салбар сургуулийн тайланг нэгтгэсэн санхүүгийн тайлантай тулгахад 39.7 сая төгрөгийн зөрүүтэй үр дүн буруу илэрхийлэгдсэн нь Сангийн сайдын 341 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

#### 2.8.1.2 Балансын данстай холбоотой асуудал

2018 оны 12 дугаар сарын 28 нд Зос трейд ХХК-ны барилгын засварын мөнгө шилжүүлж засварын ажил эхлээгүй байхад тайланд капиталжуулж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтын зөрчсөн байна.

#### 2.8.1.3 Балансын данстай холбоотой асуудал

Баянхонгор аймаг дахь салбар сургуулийн 87,5 сая төгрөгний үнэтэй хичээлийн байрыг хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй нь Сангийн сайдын 2018 оны 08 сарын 07-ны өдрийн 207 дугаар тушаалыг мөрдөж ажиллагаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

### 2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/Сая төгрөгөөр/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	57,5	
2	Албан шаардлага өгсөн	1	21.2	
	<b>Дүн</b>	<b>4</b>	<b>78.7</b>	

#### 2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### Асуудал 1: Балансын данстай холбоотой асуудал

Тус сургууль 2006 оноос өмнөх 21.2 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй тооцоо нийсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн

20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах талаар албан шаардлага өгөв.

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Төв сургуулийн 2019 онд үргэлжлэн хэрэгжих барилгын засварын гэрээнд дурдсан ажлын гүйцэтгэл биелэлтэнд анхаарал хандуулах.

## **2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар тогтоолоор 2018 оны орлого, зарлагын төсөв баталсан. Төсвийн тодотголыг 2018 оны 9 дүгээр сарын 17-ны 14 дугаар тогтоолоор улсын төсвийн санхүүжилт 147.0, орон нутгийн төсвөөс 33.7, үндсэн үйл ажиллагааны орлого 1,144.8, туслах үйл ажиллагааны орлого 365.9, нийт 1,691.3 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг баталсан байна. Орлогын гүйцэтгэл нь 1,752.8 сая төгрөг буюу 116 хувиар давж биелэсэн нь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын болон оюутны тоо нэмэгдсэн, дотуур байрыг бүрэн ажиллуулсан зэргээс шалтгаалсан. Зардлын төлөвлөгөөг цалин хөлс 1,104.8, бараа үйлчилгээний зардал 339.3, сургалт, судалгаа эрдэм шинжилгээний зардал 293.1, тогтмол зардал 146.9, хөрөнгийн зардал 122.0, нийт 1,967.5 сая төгрөгийн зардлыг баталсан байна. Зардлын гүйцэтгэл нь цалин хөлс 978.0, бараа үйлчилгээний зардал 233.7, сургалт, судалгаа эрдэм шинжилгээний зардал 127.2, тогтмол зардал 125.8, хөрөнгийн зардал 45.3, нийт 1,510.0 сая төгрөгийн зардлын гүйцэтгэл буюу 76.7 хувьтай байна.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн “[www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)/худалдаа үйлдвэрлэлийн их сургууль” цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2018 цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2018 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг 146 мэдээлэл байршуулахаас хуулийн хугацаанд 22 мэдээлэл байршуулсан. Хугацаа хоцорсон 42 мэдээлэл, огт байршуулаагүй 82 мэдээлэлтэй байна

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Анхан шатны баримтын бүрдэл хангах, хувьцаа бүртгүүлэх 2 зөвлөмжийн биелэлтийг шалгаж үзэхэд хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Албан томилолттой холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Албан томилолтын хуудас, удирдамж, гүйцэтгэсэн ажлын тайлангүйгээр 12.2 сая төгрөгийг олгосон нь “Үнэн зөв байх”, “Иж бүрэн байх”, “Тодруулга ба толилуулга” батламж мэдэгдэлүүдтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Анхан шатны баримтын бүрдэл дутуу байх, зардлыг үр ашиггүй зарцуулах.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Холбогдох журмын заалтыг хэрэгжүүлж ажиллах, томилолтын тооцоог бүрэн хийж гүйцэтгэж байх.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн

### **3.2 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр 45.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь “Иж бүрэн байх”, “Тодруулга ба толилуулга” батламж мэдэгдэлүүд нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### **3.2.2 Эрсдэл:**

Зардал хэтрэх, төсвийг үр ашиггүй зарцуулах, шаардлагагүй хөрөнгө бэлтгэх.

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Төрийн болон орон өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.

#### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн

### **3.3 Шилэн данстай холбоотой асуудал**

#### **3.3.1 Илрүүлэлт:**

2018 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг 185 мэдээлэл байршуулахаас хуулийн хугацаанд 22 мэдээлэл байршуулсан. Хугацаа хоцорсон 67 мэдээлэл, байршуулаагүй 96 мэдээлэл байгаа нь “Иж бүрэн байх”, “Тодруулга ба толилуулга” батламж мэдэгдэлүүд нийцэхгүйгээс гадна Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

#### **3.3.2 Эрсдэл:**

Байгууллагын төсвийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй биш байх,

#### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.

#### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 7 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>710,501,386.31</b>	<b>1,108,792,534.79</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>423,817,857.94</b>	<b>760,651,353.52</b>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	423,817,857.94	760,651,353.52
3121	Төгрөг	423,817,857.94	760,651,353.52
31213	Арилжааны банк дахь харилцах	423,817,857.94	760,651,353.52
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>89,342,236.57</b>	<b>194,956,386.83</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	21,700,640.00	29,771,650.00
335	Бусад авлага	67,641,596.57	165,184,736.83
3351	Байгууллагаас авах авлага	67,641,596.57	165,184,736.83
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>197,341,291.80</b>	<b>153,184,794.44</b>
354	Хангамжийн материал	197,341,291.80	153,184,794.44
35470	Бусад хангамжийн материал	197,341,291.80	153,184,794.44
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,512,691,970.53</b>	<b>8,546,063,669.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,512,691,970.53</b>	<b>8,546,063,669.00</b>
392	Биет хөрөнгө	3,378,738,470.53	6,359,708,502.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,448,502,300.50	5,801,785,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,620,237,298.36	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,299,500.00	36,299,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	36,299,500.00	36,299,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	485,531,461.68	409,955,719.21
39206	Хуримтлагдсан элэгдэл	367,348,299.31	297,978,629.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	454,271,242.21	458,500,884.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	299,780,546.92	327,999,666.27
39209	Зам, гүүрийн байгууламж/Нийтийн тохижилт	29,391,100.00	33,575,500.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	28,398,767.62	-
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	23,279,364.50
39215	Хуримтлагдсан элэгдэл		21,991,048.25
39217	Ном	276,807,278.35	280,581,178.35
393	Биет бус хөрөнгө	133,953,500.00	2,186,355,166.59
39301	Програм хангамж	4,200,000.00	7,520,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	3,400,000.00	3,993,333.41
39303	Бусад биет бус хөрөнгө	133,153,500.00	2,182,828,500.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,223,193,356.84</b>	<b>9,654,856,203.79</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>297,885,452.19</b>	<b>540,318,099.56</b>

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>297,885,452.19</b>	<b>540,318,099.56</b>
413	Өглөг	14,940,962.19	13,884,474.69
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,797,387.19	13,884,474.69
414	Урьдчилж орсон орлого	282,944,490.00	526,433,624.87
41440	Бусад урьдчилж орсон орлого	282,944,490.00	526,433,624.87
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,925,307,904.65</b>	<b>9,114,538,104.23</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,925,307,904.65	9,114,538,104.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,590,401,523.69	5,640,076,523.69
51101	Өмч: - төрийн	3,590,401,523.69	5,640,076,523.69
512	Хуримтлагдсан үр дүн	334,906,380.96	389,241,767.28
51210	Өмнөх үеийн үр дүн		334,906,380.96
51220	Тайлант үеийн үр дүн	334,906,380.96	54,335,386.32
51300	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>		<b>3,085,219,813.26</b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,223,193,356.84</b>	<b>9,654,856,203.79</b>

#### 4.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>802,441,929.68</b>	<b>1,689,668,884.57</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>473,397,514.68</b>	<b>1,371,597,074.51</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	473,397,514.68	1,371,597,074.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	473,397,514.68	1,371,597,074.51
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	329,792,520.00	1,030,180,029.63
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	143,604,994.68	341,417,044.88
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>329,044,415.00</b>	<b>318,071,810.06</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	324,044,415.00	317,471,810.06
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	32,436,825.00	150,403,490.06
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	15,816,000.00	115,028,100.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	19,642,090.00	52,040,220.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	5,000,000.00	600,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	600,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>453,285,189.72</b>	<b>1,635,333,498.25</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>453,285,189.72</b>	<b>1,635,333,498.25</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	450,394,078.72	1,599,065,433.25
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	217,827,353.54	867,281,408.58
210101	Үндсэн цалин	217,827,353.54	867,281,408.58
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,067,066.28	109,910,178.70
210201	Тэтгэврийн даатгал	24,067,066.28	109,910,178.70
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,436,826.15	141,878,047.06
210301	Гэрэл, цахилгаан	14,921,463.15	50,318,610.28
210302	Түлш, халаалт	11,276,840.00	69,278,540.00
210303	Цэвэр, бохир ус	6,238,523.00	22,280,896.78
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,033,320.05	30,391,093.40
210401	Бичиг хэрэг	840,217.02	1,300,690.00
210402	Тээвэр, шатахуун	966,000.00	5,624,365.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	697,609.00	11,114,054.29
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	6,529,494.03	12,351,984.11
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,036,255.72	19,869,202.19
210604	Урсгал засвар	8,036,255.72	19,869,202.19
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,171,430.00	15,062,702.00
210701	Гадаад албан томилолт		10,336,202.00
210702	Дотоод албан томилолт	1,171,430.00	4,726,500.00



Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	57,378,126.00	130,463,807.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,378,126.00	130,463,807.52
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	100,443,700.98	284,208,993.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,359,850.00	14,813,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,070,373.00	113,683,804.23
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,013,477.98	155,711,289.57
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,891,111.00	36,268,065.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,891,111.00	36,268,065.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,891,111.00	36,268,065.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>349,156,739.96</u></b>	<b><u>54,335,386.32</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>334,906,380.96</u></b>	<b><u>54,335,386.32</u></b>

### 4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>825,004,851.85</u></b>	<b><u>1,846,781,868.67</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>756,782,361.85</b>	<b>1,754,141,648.67</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	740,966,361.85	1,629,236,298.67
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	464,119,990.00	1,179,360,805.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	453,005,990.00	1,160,160,805.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,114,000.00	19,200,000.00
120009	Бусад орлого	276,846,371.85	449,875,493.17
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	15,816,000.00	124,905,350.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	15,816,000.00	124,905,350.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>68,222,490.00</b>	<b>92,640,220.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	43,580,400.00	40,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	43,580,400.00	40,000,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	5,000,000.00	600,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	600,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	19,642,090.00	52,040,220.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	19,642,090.00	52,040,220.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>388,072,283.91</u></b>	<b><u>1,464,660,022.09</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>388,072,283.91</u></b>	<b><u>1,464,660,022.09</u></b>
<b>210</b>	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>385,181,172.91</b>	<b>1,431,595,257.09</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	217,752,356.48	851,717,756.39
210101	Үндсэн цалин	217,752,356.48	851,717,756.39
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,067,066.28	126,259,475.85
210201	Тэтгэврийн даатгал	24,067,066.28	126,259,475.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,436,826.15	125,771,088.32
210301	Гэрэл, цахилгаан	14,921,463.15	47,247,710.23
210302	Түлш, халаалт	11,276,840.00	56,157,794.76
210303	Цэвэр, бохир ус	6,238,523.00	22,365,583.33
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,206,112.05</b>	<b>35,930,813.29</b>
210401	Бичиг хэрэг	840,217.02	3,464,140.00
210402	Тээвэр, шатахуун	966,000.00	5,624,365.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	697,609.00	11,175,304.29
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	7,702,286.03	15,667,004.00

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2106</b>	<b>Эд хогшил урсгал засварын зардал</b>	<b>8,988,632.95</b>	<b>50,666,627.54</b>
210604	Урсгал засвар	8,988,632.95	50,666,627.54
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,477,418.00</b>	<b>9,438,662.00</b>
210701	Гадаад албан томилолт	1,171,430.00	4,332,260.00
210702	Дотоод албан томилолт		5,106,402.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>27,382,200.00</b>	<b>73,774,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,382,200.00	73,774,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>60,870,561.00</b>	<b>158,036,833.70</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,363,088.00	113,527,491.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,507,473.00	44,509,342.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,891,111.00</b>	<b>33,064,765.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,891,111.00</b>	<b>33,064,765.00</b>
213209	нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,891,111.00	33,064,765.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>13,114,710.00</b>	<b>45,288,351.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,114,710.00</b>	<b>45,288,351.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>13,114,710.00</b>	<b>45,288,351.00</b>
222001	Тоног төхөөрөмж		45,288,351.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,114,710.00	
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>423,817,857.94</b>	<b>336,833,495.58</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>423,817,857.94</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>423,817,857.94</b>	<b>760,651,353.52</b>

#### 4.4 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	3,590,401,523.69		334,906,380.96	3,925,307,904.65
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,590,401,523.69</b>	-	<b>334,906,380.96</b>	3,925,307,904.65
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн				-
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,590,401,523.69</b>	-	<b>334,906,380.96</b>	3,925,307,904.65
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,590,401,523.69</b>	-	<b>334,906,380.96</b>	<b>3,925,307,904.65</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,590,401,523.69</b>	-	<b>334,906,380.96</b>	3,925,307,904.65
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		3,085,219,813.26		3,085,219,813.26
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	2,049,675,000.00			2,049,675,000.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн			54,335,386.32	54,335,386.32
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,640,076,523.69</b>	<b>3,085,219,813.26</b>	<b>389,241,767.28</b>	9,114,538,104.23

#### 4.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	423,817,857.94	423,817,857.94		-
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,967,525,000.00	1,509,948,373.09	457,576,626.91	76.7
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,845,441,800.00	1,464,660,022.09	380,781,777.91	79.4
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,766,841,500.00	1,420,470,257.09	346,371,242.91	80.4
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	985,933,100.00	851,717,756.39	134,215,343.61	86.3
Үндсэн цалин	985,933,100.00	851,717,756.39	134,215,343.61	86.3
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	118,869,100.00	126,259,475.85	(7,390,375.85)	106.
Тэтгэврийн даатгал	118,869,100.00	126,259,475.85	(7,390,375.85)	106.
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	146,918,800.00	125,771,088.32	21,147,711.68	85.6
Гэрэл, цахилгаан	55,013,800.00	47,247,710.23	7,766,089.77	85.8
Түлш, халаалт	72,154,700.00	56,157,794.76	15,996,905.24	77.8
Цэвэр, бохир ус	19,750,300.00	22,365,583.33	(2,615,283.33)	113.2
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	87,002,900.00	27,459,813.29	59,543,086.71	31.5
Бичиг хэрэг	5,252,000.00	3,464,140.00	1,787,860.00	65.9
Тээвэр, шатахуун	10,764,500.00	5,624,365.00	5,140,135.00	52.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,246,800.00	2,704,304.29	22,542,495.71	10.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	45,739,600.00	15,667,004.00	30,072,596.00	34.2
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	45,529,900.00	40,866,627.54	4,663,272.46	89.7
Урсгал засвар	45,529,900.00	50,666,627.54	-5,136,727.54	111.2
<b>Томилолт, зочны зардал</b>	34,040,500.00	10,787,210.00	23,253,290.00	31.6
Дотоод албан томилолт	4,540,500.00	4,332,260.00	208,240.00	95.4
Зочин төлөөлөгч хүлээн авах	29,500,000.00	6,454,950.00	23,045,050.00	21.8
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	142,341,900.00	134,248,794.54	8,093,105.46	94.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	132,350,100.00	115,741,134.54	16,608,965.46	87.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,900,000.00	18,507,660.00	(8,607,660.00)	186.9
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	91,800.00	-	91,800.00	-
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	206,205,300.00	103,359,491.16	102,845,808.84	50.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	206,205,300.00	103,359,491.16	102,845,808.84	50.1

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	78,600,300.00	34,389,765.00	44,210,535.00	43.7
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	78,600,300.00	34,389,765.00	44,210,535.00	43.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	78,600,300.00	34,389,765.00	44,210,535.00	43.7
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>122,083,200.00</b>	<b>55,088,351.00</b>	66,994,849.00	45.1
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	122,083,200.00	55,088,351.00	66,994,849.00	45.1
Их засвар	41,142,400.00	-	41,142,400.00	-
Тоног төхөөрөмж	42,779,800.00	38,194,451.00	4,585,349.00	89.2
Бусад хөрөнгө	38,161,000.00	7,093,900.00	31,067,100.00	18.5
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,691,216,100.00	1,846,781,868.67	(155,565,768.67)	109.2
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	146,918,800.00	41,941,500.00	104,977,300.00	28.5
Улсын төсвөөс санхүүжих	146,918,800.00	41,941,500.00	104,977,300.00	28.5
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	33,618,000.00	52,040,220.00	(18,422,220.00)	154.8
Орон нутгийн төсвөөс	33,618,000.00	52,040,220.00	(18,422,220.00)	154.8
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,510,679,300.00	1,752,800,148.67	(242,120,848.67)	116.03
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,144,796,200.00	1,302,324,655.50	(157,528,455.50)	113.76
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	365,883,100.00	450,475,493.17	(84,592,393.17)	123.12
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		423,817,857.94		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		760,651,353.52		

# ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.

